

УДК 930.85+398.8

ОРОСЫН ЭРДЭМТЭН И.И. ПОПОВЫН БИЧЛЭГТ «ЖАНГАР» ТУУЛИЙН НЭГ ДУУГ СУДЛАХ АСУУДАЛД

Мерген Владимирович Босхонджиев

PhD, доцент

Б.Б. Городовиковын нэрэмжит Халимагийн Улсын их сургууль,

Элстэй, Орос Холбоот Улс

E-mail: oirat_mergen@mail.ru

Хураангуй

Тус өгүүлэлд Оросын эрдэмтэн И.И. Поповын «Жангар»-ын судалгааны дэвтрийг сууриа болгон шинжлэхээр оролдсон болно. «Жангар»-ын нэг бүлгийн халимаг текст 14 хуудас эзэлдэг (дууны хэмжээ — 1814 яруу найргийн мөр). Дууны төгсгөлд туульчийн нэр (Бадма Доржинович Обушинов), бичлэг хийсэн огноо (шөнө, 1901 оны 12-р сар) ба газар — Дунд Аюула (одоо Ростов мужийн Целинский дүүргийн нутаг дэвсгэр) бичигдсэн байна. Текстийг кириллээр яруу найргийн мөрөнд хуваахгүйгээр, халимаг авиа, урт эгшиг заах нэмэлт тэмдгүүдийг ашиглан бичсэн. Зөвхөн хэдэн залруулга эх бичигт олдсон байна. Үгсийн бичилгээний бусад хувилбарууд хаалтанд өгсөн. Үе үеийн Оросын эрдэмтэн судлаачид И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийн тухай бага сага мэдээ сэлт олж, түүнийгээ судалгаандаа цухас дурдаж өнгөрчээ. Гэтэл зарим эрдэмтэдийн буруу зүйлсийг залруулах тулд зохиогч мөн шинэ илэрүүлсэн материалыг судалгааны эргэлтэнд оруулахын зэрэгцээгээс «Хадгаламжийн газрын асуудал», «Дэвтэрийн асуудал», «Гарчгийн асуудал», «Хуудасны асуудал» болон «Агуулгын асуудал» хэмээн таван хэсэг хувааж өөрийн үзэл санаагаа дэвшүүлэв.

Товч үг

«Жангар», И. И. Попов, дэвтэр, асуудал.

UDC 930.85+398.8

ON THE PROBLEM OF STUDYING ONE SONG OF THE EPIC “DZHANGAR” IN THE RECORDING OF THE RUSSIAN SCIENTIST I.I. POPOV

Mergen V. Boskhomdjiev

Ph.D., Associate Professor,

Kalmyk State University named after B.B. Gorodovikov,

Elista, Russian Federation

E-mail: oirat_mergen@mail.ru

Annotation

In the article, the Russian researcher I. I. Popov's research book “Jangar” has been tried to analyze as a basis. The Kalmyk text of one chapter of “Jangar” occupies 14 pages (the volume is 1814 poetic lines). At the end of the song is written the name of the storyteller (Badma Dorzhinovich Obushinov), the date of recording (night, 12. 1901) and the place — Middle Ayuula (now the territory of the Tselinsky District of the Rostov region). The text was written in Cyrillic, without dividing it into poetic lines, using additional signs to indicate Kalmyk sounds and long vowels. Only a few corrections were found in the original document. Other variants of word entries are given in parentheses. Generations of Russian scientists found little news about Popov's notebook “Jangar” and mentioned it in research. However, in order to correct the misstatements of some scientists, the author also put forward his ideas in five sections: “Depository issues”, “Manuscript classification issues”, “Table of contents issues”, “Pagination issues” and “Content issues”.

Keywords

“Jangar”, I.I. Popov, manuscript, problem.

УДИРТГАЛ

1940 онд судлаач В.А.Закруткин И.И.Поповын гар бичмэлийг (рукопись) Ростов мужийн цагдаагийн хөмрөгөөс олжээ (Омакаева, Манджиева, 2003; Омакаева, Салыкова, 2017). Тус гар бичмэл нь дэвтэрийн (конторная тетрадь) хэлбэртэй нэлээд зузаан бөгөөд нийт 155 хуудаснаас бүрдсэн юм. И.И. Поповын дэвтэр дэх тууль «Жангар»-ын текст монгол бичиг болон орос хэлний галиг үсэг, халимаг хэлээр бичигдсэн ажээ (ГАРО. Ф. 55. Оп. 1. Д. 13808). Дэвтэрийн зарим хэсгүүд орос хэлний орчуулгатай байна. Эдгээр хэсгийг И.И. Попов өөрөө орос хэлэнд орчуулсан юм ...” гэж тэрбээр анх удаа И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийн тухай мэдээлсэн юм (Калмыцкий эпос..., 1940: 4).

Уг дэвтэр бол “И.И. Поповын цуглуулсан үндэстэний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга хийгээд тайлбар. I боть. 1892 он” (дор «И. И. Поповын «Жангар»-ын дэвтэр» гэж дөхөмчилъе) гэх гарчигтай байна. Судлаач В.А. Закруткины мэдээлэлээс үзвэл (Закруткин, 1940: 5-88), И.И. Поповын дэвтэр нь чухам хэдэн хэсэг, хэдэн хуудас бөгөөд аль хэсэг нь ямар хэлээр болон үсэг бичгээр бичигдсэн нь тод бус, түүнчлэн дэвтэрийн хадгалдаж байгаа газар болон данс гэх мэтийн балархай зүйл байсаар байна. Учир нь В.А. Закруткин И.И. Поповын дэвтэрийн тухай ерөнхий мэдээлэл өгсөн.

1967 онд эрдэмтэн Ц.Д. Номинхановаас “И. И. Поповын цуглуулга нийт 9 бүтээлээс (труды) бүрджээ. Эдгээр нь одоо Ростов мужийн хөмргийн газарт хадгалагдаж байна. Үүнээс 3 дугаар нь «И.И. Поповын тайлбар, орос орчуулга болон уг бичвэртэй үндэстэний тууль «Жангар». 1892 он. (13808 данс)» болон 7 дугаараар нь «Жангар. Догшин шар Гүргүүгийн бүлэг. Обушинов Бадмын Жангарын орос орчуулга» гэх гарчигтай 2 бүтээл байна” хэмээн өгүүлжээ (Номинханов, 1967: 151-152). Эрдэмтэн Ц.Д. Номинханов И.И. Поповын бүх цуглуулгын дэвтэрийг бүтээл гэж үзсэн бөгөөд тэрбээр ямар учир шалтгаанаас И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийг тус тусдаа нь 2 дэвтэрээр дурдсан бэ? Мөн Ц.Д. Номинханов хөмргийн нэр, данс, орчуулга (хэсэг) зэрэг тодорхой бус мэдээ сэлтнүүдийг тэрбээр өгүүлэлдээ дурдсан ажээ.

2011 онд судлаач Д.В. Убушиеваас “Халимагийн аман зохиолын цуглуулагч И.И. Попов жангарч Обушинов Бадма Дорджиновичаас «Улаан Хонгор баатар Авланга хаан лугаа байр барилдсан бүлэг»-ийг тэмдэглүүлсэн билээ. 1940 онд мөн И.И. Поповын эхлүүлсэн орос орчуулгыг «Улан-Хонгорын тухай дуу» нэртэйгээр хэвлүүлжээ. 1978 онд Авланги хаантай Улаан Хонгорын баатрын тулаан) хэмээх ижил дуу халимаг хэлээр хэвлэгджээ [Джангар..., 1978, II: 354-405]. Г.И. Михайловын тэмдэглэснээр, «энэ дууг Дон халимагаас бичсэн нь сонирхолтой бөгөөд энэ нь Дон халимагуудын дунд Джангариадагийн зарим дуу байдгийг гэрчилдэг баримт юм» [Михайлов, 1978: 9]. Энэ бүлэг нь Халимагийн хүн амын дийлэнх хэсгээс тусгаарлагдан амьдарч байсан Донын халимагуудын хувилбар болох нь сонирхол татаж байна « (Кичиков, 1997: 176).

Тус гар бичмэл (рукопись) Ростов мужийн улсын архивын газарт хадгалагдаж байна. Архивын баримт (архивный документ) бичиг нь № 55 хөмрөгийн 13808 дугаартай юм. И.И. Поповын гар бичмэл нь нийт 11 хэсэгтэй буй” гэж тэрбээр өөрийн үзэлтээ дэвшүүлжээ (Убушиева, 2011: 169).

Харин судлаач Д.В. Убушиева И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийг гар бичмэл болон архивын баримт бичгээр үзсэн хийгээд түүнийг 11 хэсэг хувааж, архивын газар болон данс зэрэг мэдээнүүдийг өгүүлжээ. Гэвч Д. В. Убушиеван зарим нь (Убушиева, 2020) бодит байдалтай арай нийцэхгүй байна.

Дээрхээс үзвэл, И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийн тухай адил бус цаг үеийн судлаачид хоорондоо адил бус мэдээлэл болон үзэлтээ дурдан иржээ. Эдгээр эрдэмтэдийн судалгааны үр бүтээл хийгээд шинээр олдсон материалд суурьлан хадгаламжийн газрын асуудал, дэвтэрийн асуудал, гарчгийн асуудал, хуудасны асуудал, агуулгын асуудал зэрэг таван хэсэгт хувааж шинжилье.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нэг. Хадгаламжийн газрын асуудал

1940 онд судлаач В. А. Закруткинаас “И.И. Поповын гар бичмэл нь Ростов мужийн цагдаагийн архиваас олсон байна” (Калмыцкий эпос..., 1940: 4) гээд, тэрбээр И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийн тухай сураг зангийг хангасан юм. Гэтэл В.А. Закруткин тухайн архивын дансын тухай дурдсан зүйлс алга байна.

1967 онд эрдэмтэн Ц.Д. Номинхановаас “И.И. Поповын цуглуулга Ростов мужийн архивын газарт хадгалагдаж байна. Цуглуулгын 3 дугаар нь «И.И. Поповын тайлбар, орос орчуулга болон уг бичвэртэй үндэстэний тууль «Жангар». 1892 он. (13808 данс)» болон 7 дугаар нь «Жангар. Догшин шар Гүргүүгийн бүлэг. Обушинов Бадмын Жангарын орос орчуулга» гэх гарчигтай 2 уран бүтээл байна” (Номинханов, 1967: 151-152) хэмээн өгүүлжээ. Үүнээс харахад Ц.Д. Номинханов зөвхөн И.И. Поповын 3 дугаар дэвтэрийн дансыг дурдсан боловч, нөгөө 7 дугаар дэвтэрийг яагаад орхисон нь тод бус байна.

2011 онд судлаач Д.В. Убушиеваас “И.И. Попов гар бичмэл нь Ростов мужийн улсын архивын газарт хадгалагдаж байна. Архивын баримт бичиг нь № 55 хөмрөгийн 13808 дугаартай” (Убушиева, 2011: 169) гэж зөв өгүүлжээ.

Үнэндээ И.И. Поповын «Жангар» дэвтэрийн гадар талын хавтас дахь «И.И. Поповын цуглуулсан үндэстэний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга болон тайлбар. 1892 он» (Джангар национальная поэма в оригинальном тексте и русском переводе с примечаниями И.И. Попова. 1892 г.) гэх гарчгийн дээд талд нь «13808» дугаар байж дор талд нь «Ростов мужийн цагдаагийн архивын фонд» (Из фондов Архивного Отдела УНКВД РО) гээд бичээстэй байна.

Тус дэвтэрийн 1 дүгээр хуудасны дунд хэсгийн гарчгийн «И.И. Поповын янз бүрийн Халимагийн бүтээлийн орос орчуулга. I-дүгээр боть. 1892» (Перевод разных сочинений с калмыцкого на русский И.И. Попова. ТОМ — I-ый. 1892.) дээр талд нь «Ростов-на Дону хотын Азов ба Хар тэнгисийн Хязгаарын Архивын Захиргаан №__» (Азово-Черноморское Краевое Архивное Управление № _Ростов-на-Дону) хэмээх хөх өнгөтэй тамга буй бөгөөд дор талд нь «Эрдэм шинжилгээний-лавлах газрын НОМЫН САН. Ростов мужийн цагдаагийн улсын архив. Дугаар нь 13808.» (Науч-справоч. библиотека. Госархива УНКВ РО. Инв № 13808) гэх ногоон өнгөтэй тамга буй.

И.И. Поповын «Жангар» дэвтэрийн 2 дугаар хуудасны дунд нь «И.И. Поповын цуглуулсан үндэстэний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга болон тайлбар.

Дунд Аюла гол» (Джангар национальная поэма в оригинальном тексте и русском переводе с примечаниями И.И. Попова. 1892 г. Балка средняя Аюла (Дунда Аюль Голь) гэх гарчиг нь дор тод бичгээр «Жангар» гэж бичээстэй байна. Тус бичээсийн дор талд нь «Эрдэм шинжилгээний–лавлах газрын номын сан. Ростов мужийн цагдаагийн улсын архив. Дугаар нь 13808» (Науч-справоч. библиотека Госархива УНКВ РО. Инв № 13808) гэх ногоон өнгөтэй тамга байна. Тус хуудасны дунд хэсгийн гарчгийн дээд талын зүүн хэсэгт «Ростов-на Дону хотын Азов ба Хар тэнгэсийн Хязгаарын Архивын Захиргаан №__» (Азово-Черноморское Краевое Архивное Управление №__ Ростов-на-Дону) хэмээх хөх өнгөтэй тамгыг тонгоруулж дарсан буй.

Дээрхээс үзвэл, И.И. Поповын «Жангар» дэвтэр нь XX дугаар зууны эхний хагаст «Ростов мужийн цагдаагийн архивын фонд», «Ростов-на Дону хотын Азов ба Хар тэнгэсийн Хязгаарын Архивын Захиргаан», «Эрдэм шинжилгээний — Лавлах газрын номын сан. Ростов мужийн цагдаагийн улсын архив» зэрэг хөмрөг архивуудад шилжин хадгалагдаж байсныг мэдэж болно. 1967 онд бол «Ростов мужийн архивын газарт» шилжүүлж бүртгэлд хийжээ. Зөвлөлт улсын үед «Ростов мужийн архивын газар» гэдэг байгууллага байсан боловч, өнөө үед ОХУ-ын «Ростов мужийн улсын архивын газар» хэмээх нэртэй болсон. Судлаач Д.В. Убушиеваг үндэслэвэл, И.И. Поповын «Жангар» дэвтэр нь «Ростов мужийн улсын архивын газар»-т хадгалагдаж байгаа бөгөөд данс нь № 55 хөмрөгийн 13808 дугаартай байна гэв. Тус мэдээлэл зөв байна, учир нь миний бие тухайн байгууллагатай харилцаж лавласан юм.

Хоёр. Дэвтэрийн асуудал

Судлаач В.А. Закруткинаас “тус гар бичмэл нь том дэвтэрийн хэлбэртэй бөгөөд хэмжээгээр нэлээд зузаан ...” (Калмыцкий эпос..., 1940: 4) гэж өгүүлсэн байна. Мөн В.А. Закруткинаас “И.И. Поповын Дон мөрний Халимагуудын цоорын гагц тууль «Жангар»-ын тэмдэглэл (запись) хаана ч бар хэвлэлд ороогүй текст ...” (Калмыцкий эпос..., 1940: 4). Үүнээс үзвэл В.А. Закруткин И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийг гар бичмэл, том дэвтэр болон тэмдэглэл зэрэг 3 ухагдахуунаар үзсэн байна.

Харин эрдэмтэн Ц.Д. Номинханов И.И. Поповын цуглуулгыг судалж байхад “И.И. Поповын цуглуулга нийт 9 бүтээлээс (труды) бүрэлджээ” (Номинханов, 1967: 151-152) гэж дурдсан ажээ. Үүний дотроос 3 дугаар болон 7 дугаар нь «бүтээл» нь тууль «Жангар»-тай холбоотой юм. Эрдэмтэн Ц.Д. Номинханов И.И. Поповын бүх цуглуулгыг бүтээлээр үзсэн байна.

Түүний дараа XXI дугаар зууны судлаач Д.В. Убушиеваас “... И.И. Поповын гар бичмэл нь (рукопись) архивын баримт бичиг нь (архивный документ) ...” (Убушиева, 2011: 169) гэж тэрбээр И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийг гар бичмэл болон архивын баримт бичиг зэрэг 2 адил бус нэр томъёогоор дурдаж байна.

Дээрхээс үзвэл, Оросын судлаач В.А.Закруткин, Ц.Д. Номинханов болон Д.В. Убушиева нар И.И. Поповын «Жангар»-ыг гар бичмэл, том дэвтэр, тэмдэглэл, бүтээл болон архивын баримт бичгээр зэрэг (Калмыцкий эпос..., 1940: 4) ухагдахуунаар нэрлэж ирсэн түүхтэй. Гэтэл И.И. Поповын «Жангар»-ын уг эхийг нь үзвэл тэр болбол дэвтэрийн хэлбэртэй мөн. Иймээс бид «Жангар» судлал дахь И.И. Поповын «Жангар»-ыг дэвтэр хэмээв.

Гурав. Хуудасны асуудал

Судлаач В.А. Закруткинаас “... нийт 155 хуудаснаас бүрэлдэв” (Калмыцкий эпос..., 1940: 4) хэмээн дурдсан билээ. Гэхдээ В.А. Закруткин ямар арга барилаар И.И. Поповын «Жангар» дэвтэрт нийт 155 хуудастай байсныг тайлбарлахгүйгээр зөвхөн өгүүлсэн байна. Дараах үеийн судлаачид И.И. Поповын «Жангар» дэвтэрийн хуудасны тухай өгүүлэл зохиолдоо дурдсангүй байсаар иржээ. И.И. Поповын уг дэвтэрээс харвал хуудасны дугаарыг 4 янзаар дугаарласан байна. Үүнд:

1. Ром тооны дугаар: Ром тооны дугаар нь «Удиртгал» хэсгээс эхэлсэн боловч тус хуудас дахь «I»-дүгээр гэж дугаар тавиагүй байна. Харин дараах хуудаснаас «II»-дугаараас «VIII»-дугаар иймхүү бичээс хуудасны дээд талын дунд хэсэгт гараар бичсэн байна. Даруй И.И. Поповын «Жангар» дэвтэр дотор Ром тооны дугаар тус дэвтрийн эхний найман хуудасныг өөрөө И.И. Попов дугаарласан байх юм. Тус дэвтэрийн бусад хуудас дахь Ром тооны дугаар байхгүй байна.

2. Араб тооны дугаар: Араб тооны дугаар нь «Жангар. Догшин Шар Гүргүүгийн бүлэг», «Орчуулга. I дүгээр хэсгийн» (Перевод. I-ый отрывок), «2 дугаар хэсэг» (2-ой отрывок) болон «3 дугаар хэсэг» (3-ий отрывок) зэрэг дөрвөн гарчигтай хэсгийг гараар дугаарласан ажээ. «Жангар. Догшин Шар Гүргүүгийн бүлэг» гэх хэсэг 1-36 дугаар хуудсанд байрласан ч түүний эхний «I»-дүгээр тооны бичээс байхгүй байна, харин дараах хуудасны «2»-дугаараас шууд эхэлж байна. «Орчуулга. I дүгээр хэсгийн» (Перевод. I-ый отрывок) хэмээх хэсэг 37-42 дугаар хуудас дээр орсон юм. «2 дугаар хэсэг» (2-ой отрывок) гэдэг нь 43-47 дугаар хуудас мөн «3 дугаар хэсэг» (3-ий отрывок) нь 44-47 хуудсанд буй. Эдгээр Араб тооны дугаар дээд талын дунд хэсэгт тавьсан байна. Зөвхөн дээр дурдсан гурван хэсэгт ийм Араб тооны дугаар илэрч байгаа юм.

3. И.И. Поповын «Жангар» дэвтэрийн дээд талын баруун хэсгийн өнцөг болон дээд талын зүүн хэсэгт гараар бичсэн дугаарлал буй. Ингэж хуваасан учир нь нэг хуудасны хоёр талыг нь тодруулахын төлөө юм. Яагаад гэвэл дээд талын баруун хэсгийн өнцөгт Араб тооны дугаарыг тавьсан бол нөгөө дээд талын зүүн хэсэгт дугаарыг бичсэнгүй байна. Мөн дээд талын зүүн хэсгийг дугаарлахад нөгөө нь байхгүй байна. Өөрөөр хэлбэл тус 2 Арабын тооны дугаар ээлжлэн илэрч байгаа юм. Гэтэл ээлжлэн дугаарлал нь заримдаа тасарч дугааргүй үзэгдэл байна. Мөн дээд талын баруун хэсгийн өнцөгт байгаа дугаар нь уг дэвтэрийн дундаас нь өөр тооны дугаараар өөрчлөгдсөн ажээ. Иймээс тус хуудасны дугаарлал зарим хэсэгт шал өөр тоогоор тавигдаж, хуудас бүхэнд тавигдахгүй зэрэг будлиантай үзэгдэл олон оршиж буй.

4. И.И. Поповын «Жангар» дэвтэрт архивын дугаарласан тооны дугаар зэрэгцэн хуудасны дээд талын баруун хэсэгт гарч ирдэг. Гэтэл тус дугаарлал бас асуудалтай байна. Учир нь эхний хэсэгт нэг хуудасныг дан тооноор дугаарлаж байсан ажээ. Дараа нь нэг хуудсныг хоёр талтай ганц дугаар тавигдсан үзэгдэл гарсан бөгөөд хэсгүүдийн хооронд хуудасны дугаарлал алга байна, өөр тооны дугаараар эхэлдэг юм. Энэ хуудасны дугаарыг ойлгоход маш хүчиртэй, хоорондоо зөрчилтэй.

Дээрхээс үзвэл И.И. Поповын «Жангар» дэвтэр дэх хуудас дугаарлах баримжаа иль тодорхой бус байна. Магадгүй тус дэвтэрт орсон хэсгүүдийг сүүлд нь нийлүүлсэн учраас хуудсны дугаар адилгүй байж мэднэ. Түүнчлэн янз бүрийн тооны дугаар хоорондоо холилдох, тасрах буюу гэнэт хувиран өөрчлөгдөх зэрэг үзэгдэл гарсан

болхоор чухам аль нь зөв гэхэд хэцүү байна. Иймээс бид И.И. Поповын «Жангар» дэвтэрийн хуудас бүхнийг нь дан тоогоор үзсний улмаар тус дэвтэр нь нийт 191 хуудаснаас бүрэлдсэн гэх үзэлтийг дэвшүүлж байна.

Дөрөв. Гарчгийн асуудал

Эрдэмтэн Ц.Д. Номинханов “И.И. Поповын цуглуулга дахь 3 дугаар нь «И.И. Поповын тайлбар, орос орчуулга болон уг бичвэртэй үндэстэний тууль «Жангар». 1892 он. (13808 данс)» болон 7 дугаараар нь «Жангар. Догшин шар Гүргүүгийн бүлэг. Обушинов Бадмын Жангарын орос орчуулга» гэх гарчигтай 2 бүтээл байна” (Калмыцкий эпос..., 1940: 4) хэмээн өгүүлжээ. Үүнд «Догшин шар Гүргүүгийн бүлэг» бол тод үсгийн «Жангар»-ын текст байна. Харин «Обушинов Бадмын Жангарын орос орчуулга» бол жангарч Обушинов Бадмын «Жангар»-ын орос орчуулга байна. Өөрөөр хэлвэл, энэхүү хоёр бүтээл биеэ даасан текст байна.

Одоо болтол Ц.Д. Номинханов яагаад И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийг 2 бие даасан дэвтэрээр үзсэн нь тодорхой бус байна. Тухай үед И.И. Поповын «Жангар»-ын дэвтэр нь архивт хадгалагдаж байх үед 2 салангид дэвтэр байсан юм. Дараа нь архивын ажилчид нийлүүлсэн ч байж болно. Харин одоо уг дэвтэрийн гадар тал дээр нь “И.И. Поповын цуглуулсан үндэстэний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга болон тайлбар. I боть. 1892 он” гэх гарчигтай.

Тав. Агуулгын асуудал

2011 онд Д.В. Убушиеваас “... И.И. Поповын гар бичмэл нь нийт 11 хэсэгтэй буй” (Убушиева, 2011: 169) гэж тэрбээр дурдсан билээ. Судлаач Д.В. Убушиева И.И. Поповын «Жангар»-ын дэвтэр дахь 11 хэсгээс бүрэлдсэн юм. Үүнд:

“1. «И.И. Поповын цуглуулсан үндэстэний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга болон тайлбар. I боть. 1892 он. Ростов мужийн цагдаагийн арихийн фонд» (ДЖАНГАР. Национальная поэма в оригинальном тексте и русском переводе с примечаниями И.И. Попова. 1892 г. Из фондов Архивного Отдела УНКВД РО)).

2. «Удиртгал» (Предисловие)

3. «Тод үсгийн «Жангар» болон түүний орчуулга»

4. «Халимагууд «Жангар»-ын хүнд үгсийг тайлбарж өгсөн нь»

5. «Обушинов Бадмын «Жангар»-ын үгсийг тайлбарлаж өгсөн нь»

6. «Обушинов Бадмын хэлсэн «Жангар»-ын нэг бүлгийн текст»

7. «Обушинов Бадмын хэлсэн «Жангар»-ын орос орчуулга»

8. «Дон мөрний халимагуудын ардын аман зохиол дахь цэрэг-туужийн дууны тухай» гэдэг гарчигтай Дон музейд миний бичсэн зарим мэдээлэл»

9. «Халимагууд «Жангар»-ын хүнд үгсийг тайлбарлаж тодорхойлсон ба нэмлэт хийсэн нь»

10. «Жангар»-ын орос орчуулгын хэсгүүд»

11. «Кирсан гэдэг хүний «Жангар»-ын 2 дугаар хэсгийн тайлбар» зэрэг нийт 11 хэсгээс И.И. Поповын «Жангар»-ын дэвтэр бүрэлдсэн байна” (Убушиева, 2011: 169-170) хэмээв.

Бидний үзэхэд, И.И. Поповын «Жангар» дэвтэр нь судлаач Д.В. Убушиева өгүүлсэн 11 хэсгээс жаахан илүү байна. Учир нь Д.В. Убушиеван 3 дугаар хэсэг нь бие даасан 4 хэсэгт хувааж болно мөн 4 дугаар хэсгийг тус тусдаа 2 хэсгээр үзэж болно. Яагаад гэвэл, И.И. Поповын хэсэг болгон өөрийн гарчигтай (үүний дотроос

зөвхөн нэг хэсэг гарчиггүй боловч түүний агуулгаас үзвэл тусгай хэсгээр үзэж болно) улмаас тус тусдаа нь хэсгүүдээр хувааж болох юм байна. Мөн Д.В. Убушиева өөрийн өгүүлэлд И.И. Поповын «Жангар»-ын дэвтэр дэх 1-дүгээр хэсгийг яагаад тусгай хэсгээр өгүүлсэн нь тодорхой бус байна. Харин «И.И. Поповын цуглуулсан үндэсний тууль «Жангар»-ын уг текст, орос орчуулга болон тайлбар. I боть. 1892 он. Ростов мужийн цагдаагийн арихивын фонд» буюу 1-дүгээр хэсэг нь бол И.И. Поповын «Жангар»-ын дэвтэрийн гарчиг байна. Иймээс Д.В. Убушиевын өгүүлэл дэх И.И. Поповын «Жангар» дэвтэрийг 11 хэсгээр хуваах баримжаа балархай мөртлөө дээр илэрсэн хэдэн асуудал оршиж байгаа юм. Энд суурилан дор И.И. Поповын «Жангар» дэвтэрийн хэсгүүдийг дэс дарааллаар хувааж өгүүлэх шаардалгатай байна. Үүнд:

1.1 «Удиртгал» хэсэгт тууль «Жангар»-т холбогдох цээр хорь, жангарч нарын хайлах арга барил, шагнал, Халимагуудын түүхийн чухал сураг зангийг бичсэн ажээ. Тухайбал И.И. Поповаас «Халимаг үндэстний тууль Жангар бол ардын аман зохиолын бүтээл мөн. Тус тууль монголчуудын нэг хэсэг болсон Ойрадын хүсэл мөрөөдөл нь болдог. «Жангар» хэмжээгээр нь том 99 цагаан тэмээний ачаа болж чаддаг. Тууль «Жангар»-т дурлан сонсож болохгүй гэнээ, яагаад гэвэл тус тууль хүний сэтгэлийг их татдаг. Жангарч болсон хүн өөрийн амьдралыг хаяад «Жангар»-ыг хайлж аймаг тойрч явдаг. Жангарч болсон хүний амьдрал нь ядуурна. Анх «Жангар»-ыг нас барсны дараа амилсан хүн хайлсан болхоор тэрбээр нэгэнт сүнс байж, удам залгамжлах хүүхэдгүй байжээ. Иймээс «Жангар»-ыг хайлвал үр хойчис үгүй, удам тасран гэж Дон мөрний Халимагууд ярьдаг гэнээ. Дон Халимагуудын дээд аймагуудад настай, ядуу, гэр бүлгүй жангарч байлаа. Тэр настай жангарч «Жангар» хайлахаас өмнө талх болон шар тосыг гуйдаг байжээ. Түүний цүнх дотор «Жангар»-ын нэг судар байсан боловч тэрбээр аймаг тойрч туулийг хайлах үед сударыг харахгүйгээр олонх мөрийг өөрөө өөрчилж буюу зохиож хайлдаг байсан. 15-20 жилийн өмнө Дон Халимагуудын дунд жангарч цолтой тусгай хүмүүс байсан. Одоо бол залуучуудаас «Жангар»-ыг хэлж хайлдаг чаддаг хүмүүс бий» гэж судлаач дурджээ. Мөн удиртгалын сүүлийн хэсэгт «Жангар»-ын судлаач нарын (Б. Бергман, А.А.Бобровников, К.Ф.Голстунский, А.М. Позднеев) тухай сураг занг болон тэдний судалгааны талаар өөрийн үзлтийг бичсэн юм.

1.2. «Жангар. Догшин Шар Гүргүүгийн бүлэг» гэх тод үсгээр бичигдсэн тууль «Жангар»-ын агуулгын талаар хагас дутуу мөртлөө ирэл гарлын тухай сураг зангийг тушаасангүй бүлэг байна.

1.3. “Орчуулга. I дүгээр хэсэг”;

1.4. “2 дугаар хэсэг”;

1.5. “3 дугаар хэсэг” хэмээх 3 гарчиг дахь «Жангар»-ын орос орчуулга орсон.

1.6. “«Жангар»-ын хүнд үгсийг тайлбарласан” гэдэг хэсэгт «Жангар»-ын халимаг хэлний нийт 450 үгийг орос хэлээр орчуулан тайлбар хийжээ;

1.7. “Жангар-ын 2 дугаар бүлгийн үгс” хэмээх хэсэгт нийт 56 үг орос хэлээр орчуулан тайлбарласан;

1.8. Тус хэсэг гарчиггүй боловч И.И. Попов Б.Бергманы 1804 онд хэвлүүлсэн тууль «Жангар»-ын тухай сураг зангийг герман хэлнээс орос хэлэнд орчуулж 2 хуудас дээр багтаасан байна;

1.9. “Обушинов Бадмын «Жангар»-ын үгсийг тайлбар” хэмээх хэсэг урьдаар халимаг хэлний 58 үгийг орос хэлээр орчуулан тайлбар хаджээ. Тус хэсгийн төгсгөлд нь “1901 оны 12 сарын 20 өдөр. Шөнө. 11 цаг. Дунд Аюла” гэж бичжээ. Үүнээс үзвэл И.И. Попов он, сар өдөр, цаг хугацаа, газар орон зэрэг чухал сураг занги үлдээсэн магтууштай байна. Бидний мэдсэнээр И.И. Попов 1901 оны 12 сарын 9 өдөр Обушинов Бадмаас уг туулийг тэмдэглэн авсан билээ. Үүнээс үзвэл үгсийн тайлбар хийх явцдаа бузав жангарчтай дахиад нэг удаа очиж уулзсан байна гэж тус хэсгээс ойлгож болно;

1.10. “Обушинов Бадмын «Жангар»-ын нэг бүлгийг хайлсан халимаг текст” гэж гарчигт И.И. Поповын гар бичмэл мөн байна;

1.11. “Обушинов Бадмын «Жангар»-ын орос орчуулга” гэдэг гарчигт уг халимаг гар бичмэл «Жангар»-ын сүүлийн хэсгийн орос орчуулга буй;

1.12. “Дон мөрний халимагуудын ардын аман зохиол дахь цэрэг-туужийн дууны тухай» гэдэг Дон музейд миний бичсэн зарим мэдээлэл” хэмээх урт гарчигтай хэсэгт И.И. Попов өөрөө Дон музейд яаж тус мэдээллийг бичсэний тухай эхний нүүрт бичжээ. Дараа нь халимагууд Орос руу нүүж ирсэн өмнөх болон дараах үеийн түүх, халимагуудын цөс зориг ардын аман зохиолд тусгагдсан болон сүүлийн хэсэгт тус дэвтэрийн оршлын хэсгээс «Жангар»-ын тухай бага сага сураг зангийг бичиж оруулжээ;

1.13. “Халимагуудын тайлбарласан хүнд үгсийн тодорхойлолт ба нэмэр” хэмээх хэсэгт халимаг хэлний нийт 12 үгийг оросоор орчуулан тайлбар хадсан байна;

1.14. “Жангар. 2 дугаар бүлэг” гэдэг хэсэгт уул бүлгийн орос хэлний орчуулга бий;

1.15. “Жангар. 2 дугаар бүлгийн 8 дугаар хэсгийн үргэлжлэл” гэдэг хэсэгт оросоор тайлбарласан халимаг хэлний нийт 41 үгийн тайлбар буй;

1.16. “Жангар»-ын 2 дугаар хэсэгт Кирсан гэх хүний үгсийн тайлбар буй. Үүнд халимаг хэлний нийт 454 үгийн орос тайлбар байна.

Дээрхээс үзвэл, И.И. Поповын «Жангар»-ын дэвтэр нийт 16 хэсгээс бүрэлдсэн байна. Эдгээрээс нь зарим нэгэн хэсэг нь урт байж, зарим нь гэвэл богино байна. Мөн тод үсэг, орос хэлний галиг үсэг, орос хэлний орчуулга, үгийн тайлбар болон бусад мэдээлэлийг тухай үед И.И. Попов цуглуулж судалгаа хийж өөрийн дэвтэрт бичиж үлдээсэн байжээ. Энэхүү үйл ажиллагаа нь 100 жилийн өмнө хийгдсэн боловч өнөө цагийн «Жангар» судлалд авч хэлбэл И.И. Попов чухал эх хэрэглэгдэхүүнийг хангажээ.

ДҮГНЭЛТ

Өнгөрсөнд Оросын эрдэмтэд И.И. Попов «Жангар» дэвтэрийн тухай өдий төдий мэдээлэл хийж байсан боловч нарийн таницуулга хийх буюу цаашид тусгайлан судласангүй. Үүнд судлаач Д.В. Убушиеваас И.И. Поповын «Жангар» дэвтэр нь «Ростов мужийн улсын архивын газар»-т хадгалагдаж байгаа бөгөөд данс нь № 55 хөмрөгийн 13808 дугаартай» гэсэн мэдээлэл зөв байна.

И.И. Попов өөрийн дэвтэртээ «Жангар»-ын «Догшин Шар Гүргүүгийн бүлэг»-ийг тод үсгээр бичсэн ба Халимагийн бузав ястны тууль «Жангар»-ын жангарч Обушинов Бадамын нэг бүлгийг тэмдэглэж түүнийгээ оросоор орчуулж,

үгсийн тайлбар хийв. Түүнчлэн тэрбээр Дон мөрний Халимагийн бузав ястны тууль «Жангар»-ын аман уламжлалын талаар ажиглалт хийснээр үл барам, XIX дүгээр зууны «Жангар»-ын судалгааны байдлын тухай өөрийн үзэлтээ дурьджээ. Үүнээс харвал XIX дүгээр зууны сүүлийн үеэс болон XX дугаар зууны эхний үед дэлхийн «Жангар» судлалын түүхэнд И.И. Попов бусад эрдэмтэдээс илүү «Жангар»-ыг идэвхий судлаж байв. Иймээс түүнийг «Жангар» судлаачаар үзэх ёстой мөртлөө түүний «Жангар» дэвтэрийг олон нийтийн гарын авлага болгох нь чухалтай.

Н о м з ү й

Государственный архив Ростовской области (ГАРО). Ф. 55. Оп. 1. Д. 13808.

Джангар. Калмыцкий героический эпос (тексты 25 песен) (1978). 1-2. Сост. А. Ш. Кичиков; ред. Г. И. Михайлов. Москва: Наука.

Закруткин, В.А. К истории изучения «Джангара» (1940) / *Калмыцкий эпос «Джангар»* / Ред., вступ. ст. и прим. В.А. Закруткина. Ростов н/Д: Ростовское областное книгоиздательство. 5–88.

Калмыцкий эпос «Джангар» (1940) / Редакция, вступит, статья и примеч. В. А. Закруткина. Ростов-на-Дону: Ростовское областное книгоиздательство.

Кичиков, А. Ш. (1997). *Героический эпос «Джангар». Сравнительно-типологическое исследование памятника.* Москва: Вост. лит.

Михайлов, Г. И. Предисловие (1978). *Джангар. Калмыцкий героический эпос (тексты 25 песен).* Т. 1. Москва: Наука. 5-25.

Номинханов, Ц.-Д. (1967). Наследие калмыковеда И. И. Попова. *Ученые записки КНИИЯЛИ. Серия «Филология».* Элиста. 5. 151–154.

Омакаева, Э. У. (2003). Актуальные проблемы современного джангароведения / Э. У. Омакаева, Б. Б. Манджиева. *Монголоведение. 2.* Элиста: Калмыцкий институт гуманитарных исследований РАН. 26–39.

Омакаева, Э. У. (2017). Из истории записи, публикации и научного изучения калмыцкого героического эпоса «Джангар» в контексте актуализации историко-культурного наследия монголо-язычных народов / Э. У. Омакаева, В. В. Салыкова. *Сетевое востоковедение: образование, наука, культура: Материалы Международной научной конференции, Элиста, 07–10 декабря 2017 года.* Элиста: Калмыцкий государственный университет имени Б.Б. Городовикова, 250-255.

Убушиева, Д.В. (2011). Песня «О битве богатыря Алого Хонгора с Авланги ханом» в записи от Бадмы Обушинова (к вопросам текстологии). *Вестник КИГИРАН.* 1. 168–173.

Убушиева, Д.В. (2020). Песнь «Об Улан Хонгоре» донского калмыка Б. Обушинова в записи И.И. Попова (1901 г.). *Новый филологический вестник.* 4 (55). 388–398.

Жанһр: Арг Улан Хонһрин туск дуд (1940). Элст.

N o m z ү j

Dzhangar. Kalmyczkij geroicheskij epos (teksty 25 pesen) (1978). 1-2. Sost. A. Sh. Kichikov; red. G. I. Mixajlov. Moskva: Nauka.

Dzanһr: Apg Ulan Xonһrin tusk dud (1940). Elst.

Gosudarstvennyj arxiv Rostovskoj oblasti (GARO). F. 55. Op. 1. D. 13808.

Kalmyczkij epos «Dzhangar» (1940) / Redakciya, vstupit. stat'ya i primech. V. A. Zakrutkina. Rostov-na-Donu.

Kichikov A. Sh. (1997). *Geroicheskiy e'pos «Dzhangar». Sravnitel'no-tipologicheskoe issledovanie pamyatnika*. Moskva: Vost. lit.

Mixajlov, G. I. Predislovie (1978). *Dzhangar. Kalmyczkij geroicheskiy epos (teksty 25 pesen)*. T. 1. Moskva: Nauka. 5-25.

Nominxanov, Cz.-D. (1967). Nasledie kalmy'koveda I. I. Popova. *Uchenye zapiski KNIIYaLI. Seriya «Filologiya»*. Elista. 5. 151–154.

Omakaeva, E. U. (2003). Aktual'ny'e problemy' sovremennogo dzhangarovedeniya / E. U. Omakaeva, B. B. Mandzhieva. *Mongolovedenie*. 2. Elista: Kalmyczkij institut gumanitarnyx issledovanij RAN. 26–39.

Omakaeva, E. U. (2017). Iz istorii zapisi, publikacii i nauchnogo izucheniya kalmyczkogo geroicheskogo eposa «Dzhangar» v kontekste aktualizacii istoriko-kul'turnogo naslediya mongoloyazychnyx narodov / E. U. Omakaeva, V. V. Salykova. *Setevoe vostokovedenie: obrazovanie, nauka, kul'tura: Materialy Mezhdunarodnoj nauchnoj konferencii, Elista, 07–10 dekabrya 2017 goda*. Elista: Kalmyczkij gosudarstvennyj universitet imeni B.B. Gorodovikova, 250-255.

Ubushieva, D.V. (2011). Pesnya «O bitve bogatyrya Alogo Xongora s Avlangi xanom» v zapisi ot Badmy Obushinova (k voprosam tekstologii). *Vestnik KIGI RAN*. 1. 168–173.

Ubushieva, D.V. (2020). Pesn' «Ob Ulan Xongore» donskogo kalmyka B. Obushinova v zapisi I.I. Popova (1901 g.). *Novyj filologicheskij vestnik*. 4 (55). 388–398.

Zakrutkin, V.A. K istorii izucheniya «Dzhangara» (1940) / *Kalmyczkij epos «Dzhangar»* / Red., vstup. st. i prim. V.A. Zakrutkina. Rostov n/D: Rostovskoe oblastnoe knigoizdatel'stvo. 5–88.